



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 09 сарын 06 өдөр

Дугаар СХЕЕ - 2024/09

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн  
санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт  
шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан  
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Монгол Улсын Соёлын Сайдын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн ХШҮДАГ-2024/ДА/14 дугаартай “Соёлын сайд буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж”, Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын “Санхүүгийн хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагаанд Монгол улсын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөрөнгө оруулалт, санхүүгийн мэдээллийг шалган дүгнэх, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга, улсын ахлах байцаагч Т.Одсүрэн ахалж, бүрэлдэхүүнд дотоод аудитор Х.Батбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад Соёлын яамны харьяа Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан /цаашид Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан/-гийн 2024 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь улсын бүртгэлийн 9057145 дугаар регистртэй, Төрийн сангийн үндсэн үйл ажиллагааны 100130035022, орон нутгийн санхүүжилтийн 100130035011, нэмэлт санхүүжилтийн 100130035403 дугаар данс болон санхүү, татварын баримтад 1-р гарын үсгийг Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн захирал С.Шинэчимэг, 2-р гарын үсгийг Ерөнхий нягтлан бодогч П.Ууганбилэг нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайланг гаргаж ирсэн байна.

1.5 Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн захирлын 2024 оны А/08 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн зохион байгуулалтын бүтэц орон тоог 02 дугаар хавсралтаар Захиргааны аж ахуйн тасаг, Лавлагаа мэдээлэл, арга зүйн

4324001113

тасаг, Уншлага үйлчилгээний тасаг зэрэг бүтэц зохион байгуулалтаар ТҮСБ-1, ТҮСУ-10, ТҮМ-2, ТҮ-5 нийт 19 албан хаагчтай байхаар шинэчлэн батлагдсан.

2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр орон тооны хангалт **16 Төрийн үйлчилгээ соёл урлагийн 2, төрийн үйлчилгээний мэргэжлийн 1 албан хаагч дутуул** орон тоотой ажилласан байна.

## Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

### 2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 02 сарын 07-ны өдрийн А/40 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ыг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийн хөтлөн явуулж байна.

Төрийн албаны Зөвлөлөөс төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор зохион байгуулдаг “Пүрэв” гарагийн буюу “7:4:10” арга зүйн 13 удаагийн сургалтад байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдсан байна. Мөн дээд шатны байгууллагаас зохион байгуулсан мэргэжил арга зүйн сургалтад албан хаагчдыг тухай бүр нь хамруулсан.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу 2024 оны эхний хагас жилийн байдлаар 1,642.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлсэн байна. 2024 оны төсвийн төлөвлөлтийг хийхдээ төсвийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй байна.

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2024 оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
131105	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого	0	1,642.00
	Номын сангийн картын орлого	0	562.00
	Түрээсийн орлого /Англи хэлний курс/	0	1,080.0

### 2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

#### Батлагдсан төсөв:

2024 оны эхний хагас жилийн байдлаар 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 316,426.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 302,351.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

**2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав:**

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

Данс	Үзүүлэлт	2024 оны эхний хагас жил		Хэмнэлт /+/ Хэтрэлт /-/ Зөрүү
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	
	<b>ХӨТӨЛБӨР 71702</b>			
	<b>АРГА ХЭМЖЭЭ 80101</b>			
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	213,501.2	204,893.5	8,607.7
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	213,501.2	204,893.5	8,607.7
210	Бараа, үйлчилгээний зардал	213,501.2	204,893.5	8,607.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,142.8	176,930.5	1,212.3
210101	Үндсэн цалин	118,089.0	115,837.6	2,251.4
210102	Нэмэгдэл	36,612.6	31,557.2	5,055.4
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	8,772.0	18,415.1	(9,643.1)
210104	Урамшуулал	14,669.2	11,120.5	3,548.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,268.4	22,268.4	-
210201	Тэтгэврийн даатгал	15,142.3	15,142.3	-
210202	Тэтгэмжийн даатгал	1,781.4	1,781.4	-
210203	ҮОМШӨ ний даатгал	890.8	890.8	-
210204	Ажилгүйдлийн даатгал	890.8	890.8	-
210205	Эрүүл мэндийн даатгал	3,563.1	3,563.1	-
2104	Хангамж, бараа материалын зардал	6,390.0	4,350.0	2,040.0
210401	Бичиг хэрэг	900.0	248.6	651.4
210402	Тээвэр (шатахуун)	900.0	425.0	475.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	450.0	1,274.0	(824.0)
210404	Ном, хэвлэл	3,000.0	1,427.3	1,572.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240.0	100.0	140.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	900.0	875.1	24.9
2106	Эд хогшил худалдан авах	2,400.0	-	2,400.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,400.0	-	2,400.0
2107	Томилолт, зочны зардал	1,500.0	1,014.6	485.4
210702	Дотоод албан томилолт	1,500.0	1,014.6	485.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,000.0	330.0	670.0
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	600.0	-	600.0
210806	Мэдээллийн технологийн зардал	400.0	330.0	70.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800.0	-	1,800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800.0	-	1,800.0
	<b>АРГА ХЭМЖЭЭ 80111</b>	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,338.6	12,650.6	11,688.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	24,338.6	12,650.6	11,688.0
210	Бараа, үйлчилгээний зардал	24,338.6	12,650.6	11,688.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,838.6	12,650.6	11,188.0
210301	Гэрэл цахилгаан	2,094.0	514.0	1,580.0
210302	Түлш, халаалт	20,460.6	10,871.3	9,589.3
210303	Цэвэр, бохир ус	1,284.0	1,265.2	18.8
2106	Эд хогшил худалдан авах	500.0	-	500.0
210604	Урсгал засвар	500.0	-	500.0
	<b>АРГА ХЭМЖЭЭ 80215</b>	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,000.0	5,000.0	-

21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	5,000.0	5,000.0	-
210	Бараа, үйлчилгээний зардал	5,000.0	5,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,000.0	5,000.0	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000.0	5,000.0	-
	ХӨТӨЛБӨР 71702	-	-	-
	<b>АРГА ХЭМЖЭЭ 80802</b>	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,436.9	37,059.5	10,377.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	47,436.9	37,059.5	10,377.4
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,436.9	37,059.5	10,377.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,436.9	37,059.5	10,377.4
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,158.9	29,781.5	10,377.4
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	7,278.0	7,278.0	-
	<b>АРГА ХЭМЖЭЭ 81855</b>	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,900.2	4,001.7	20,898.5
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	24,900.2	4,001.7	20,898.5
210	Бараа, үйлчилгээний зардал	21,165.2	4,001.7	17,163.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,320.0	3,098.7	221.3
210104	Урамшуулал	3,320.0	3,098.7	221.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	415.0	415.0	-
210201	Тэтгэврийн даатгал	282.2	282.2	-
210202	Тэтгэмжийн даатгал	33.2	33.2	-
210203	ҮОМШӨ ний даатгал	16.6	16.6	-
210204	Ажилгүйдлийн даатгал	16.6	16.6	-
210205	Эрүүл мэндийн даатгал	66.4	66.4	-
2106	Эд хогшил худалдан авах	9,960.1	-	9,960.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,960.1	-	9,960.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7,470.1	488.0	6,982.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,470.1	488.0	6,982.1
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,735.0	-	3,735.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,735.0	-	3,735.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,735.0	-	3,735.0
	<b>АРГА ХЭМЖЭЭ 83603</b>	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,250.0	61.0	1,189.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,250.0	61.0	1,189.0
210	Бараа, үйлчилгээний зардал	1,250.0	61.0	1,189.0
2104	Хангамж, бараа материалын зардал	950.0	-	950.0
210401	Бичиг хэрэг	300.0	-	300.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	650.0	-	650.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	300.0	61.0	239.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.0	61.0	239.0
	<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>316,426.9</b>	<b>302,351.7</b>	<b>14,075.2</b>

1. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал: 2024 оны эхний хагас жилийн байдлаар үндсэн цалингийн зардлыг 2,251.4 мянган төгрөг, нэмэгдэл цалин 5,055.4 мянган төгрөг, урамшуулал 3,548.6 мянган төгрөгөөр тус тус

хэмнэгдсэн бол унаа, болон бусад нөхөн олговор 9,643.1 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. Унаа, хоолны хөнгөлөлт хэтэрсэн шалтгаан нь яамнаас төсвийг хасаж баталсантай холбоотой байна.

- 2. ЭМНДШ-ийн зардал:** Ажил олгогчоос 10%-12.5%-аар тооцон ажилтны төлсөн шимтгэлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлж, сар бүр НД 8 маягтаар тайлагнасан байна.
- 3. Урсгал зардал:** 2024 оны эхний хагас жилийн байдлаар байр ашиглалттай холбоотой тогтмол зардал гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир ус, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх зардлын гүйцэтгэл 51.9 хувийн гүйцэтгэлтэй байна.
- 4. Томилолтын зардал:** 2024 он 1,500.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар 1,014.6 мянган төгрөгийн зарцуулж тайлагнасан байна.
- 5. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5,488.0 мянган төгрөг зарцуулсан байна.
- 6. Бусад зардалд:** 2024 онд 1,250.0 мянган төгрөг батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар бараа үйлчилгээний бусад зардалд 61.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- 7. Урсгал шилжүүлэг:** 2024 оны эхний хагас жилийн байдлаар 1 албан хаагчид тэтгэвэрт гарахад нь орлого нэг удаагийн тэтгэмж 29,781.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 1 албан хаагчид 7,278.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **2.3. Санхүүгийн үйл ажиллагааны явц, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт**

**Үндсэн хөрөнгө:** Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 2024 оны эхэнд барилга байгууламж 136,932.5 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 10,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 29,910.2 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 60,023.9 мянган төгрөг, номын фонд 100,179.6 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 963.56 мянган төгрөг, программ хангамж 2,466.7 мянган төгрөг, бусад биет бус хөрөнгө 9,724.8 мянган төгрөгийн нийт 350,201.4 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй, тайлант онд 1,255.5 мянган төгрөгийн номыг төсвийн хөрөнгөөр бий болгож 351,457.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Дээрх хөрөнгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт заасан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа”-гаар тулган баталгаажуулж байгаад ямар нэгэн зөрчилгүй байна.

**Бараа материал:** 2024 онд бичиг хэргийн материал 2,929.7 мянган төгрөг, аж ахуйн материал 25,932.9 мянган төгрөг түлш, шатах тослох материал 240.00 мянган

төгрөг нийт 29,102.6 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй төсвийн хөрөнгөөр 5,208.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 4,637.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан эхний хагас жилийн байдлаар 29,673.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тайлант хугацаанд бичиг хэргийн зардалд 1,635.1 мянган төгрөг, аж ахуйн материалд 2,337.3 мянган төгрөг, шатахууны зардалд 665.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан баримтаар нотлогдож байна.

### Өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хөдлөлийн утга	Орлого зарлагын гүйлгээний утга	Өмч хөрөнгө:	
			Үндсэн хөрөнгө	Бараа материал
1	Оны эхний үлдэгдэл		350,201.4	29,102.6
2	Төсвийн эх үүсвэрээр	худалдан авсан	1,255.5	5,208.5
3	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс	шилжүүлэн авсан		
4	Бусад /дахин үнэлсэн/	шилжүүлэн авсан		
5	Бусад			
6	Орлогын дүн		1,255.5	5,208.5
7	Үйл ажиллагаанд зарцуулсан	анхан шатны баримт		4,637.4
8	Байгууллагуудад шилжүүлсэн	шилжүүлсэн		
9	Акталж данснаас хассан	тушаалаар		
10	Зарлагын гүйлгээний дүн			4,637.4
11	Оны эцсийн үлдэгдэл		351,457.0	29,673.7

### 2.4 Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024 оны эхний хагас жилийн байдлаар Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн албан хаагчдын цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

2024 онд Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ:

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Нийтийн номын сан	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Үндсэн цалин	118,089.0	115,837.6
2	Нэмэгдэл цалин	36,612.6	31,557.2
3	Урамшуулал	14,669.2	11,120.5
4	Унаа, болон бусад нөхөн олговор	8,772.0	18,415.1

5	Цалин хөлс нэмэгдэл дүн	178,142.8	176,930.4
6	Ажил олгогчоос төлөх НДШ	22,268.4	22,268.4
	Цалин хөлс НДШ-тэй холбоотой нийт зардлын дүн	200,411.2	199,198.8
	Орон тооны мэдээлэл	19	16

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь нийт 16 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 200,411.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 199,198.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоолт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад авлага үүсгээгүй байна.

## **2.5 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт**

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх томоохон худалдан авалт хийгдээгүй байна.

## **2.6. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих**

### **1. Анхан шатны баримтын бүрдэл**

- Бараа материалын худалдан авалт, анхан шатны баримтын иж бүрдлийг тулган шалгахад тайлант хугацаанд хийгдсэн худалдан авалт нь хууль, журмын дагуу бүртгэгдсэн байна.

### **2. Шатахуун зарцуулалт**

“НИК” ХХК-тай гэрээ байгуулж, шатахууны талон ашиглан эхний хагас жилийн байдлаар 645.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Анхан шатны баримтын бүрдлийг тулган шалгахад:

- Жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтөлсөн боловч автомашины 100 км-д зарцуулах шатахууны нормыг /Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсаргалт “Автомашины 100км гүйлтэд зарцуулах жишиг норм”/ мөрдөөгүй.
- Автомашины шатахуун зарцуулалтын анхан шатны баримтын /бусдын тээврийн хэрэгслээр ажил үйлчилгээ гүйцэтгэсэн тохиолдолд тээврийн хэрэгслийн техникийн гэрчилгээ, жолоочийн жолооны үнэмлэхийг баримтал хавсаргах/ бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн байна.

## **3. Цалин бодолт**

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 2024 онд 16 орон тоотой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ажилчдын цалин тооцоололтыг тулган шалгахад:

- Томилолтоор ажилласан албан хаагч нарт хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон зөрчил илэрсэн.

## 2.7 Өмнөх шалгалтын талаар

Хүснэгт 5.

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн шийдвэрлэлт	2023 он				
	Үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь
Албан шаардлага	1	2,220.0	1	2,220.0	100.0
Төлбөрийн акт	1	227.5	1	227.5	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>2,447.5</b>	<b>2</b>	<b>2,447.5</b>	<b>100.0</b>

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн хяналт шалгалтаар 2023 онд Төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 2,220.0 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж дээрх алдааг давтан гаргаагүй. Мөн тус газрын захирал С.Шинэчимэгт улирлын ажлын үр дүнгийн урамшуулал илүү тооцож олгосон 227.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдсаныг бүрэн барагдуулж акт, албан шаардлагын хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

### Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлт, шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөөр хангалттай сайн, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон бол хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

### Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:

**Илрүүлэлт 1.** Автомашины 100 км зарцуулах зарцуулалтын жишиг нормыг мөрдөөгүй 640.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэг, гуравдугаар хавсралттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт** Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

**Илрүүлэлт 2.** 2024 оны эхний хагас жилийн байдлаар ажиллагчдын унаа, хоолны хөнгөлөлтийг батлагдсан төсвөөс хэтрүүлэн 9,643.1 мянган төгрөг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”: 16.5.2 “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;*”, 16.5.5 “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт** Дээд шатны төсвийн захирагчийн баталсан төсвийн зардлын хүрээнд унаа, хоолны хөнгөлөлтийг тооцож олгож байх зөвлөмжийг хүргүүлэв.

**Илрүүлэлт 3.** 2024 оны төсвийн төлөвлөлтийг хийхдээ үндсэн үйл ажиллагаанаас бий болох өөрийн орлогын төлөвлөж батлуулаагүй атал орлого төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.”, 5.1.2 “*Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт** Төсвийн орлогыг хууль, эрхийн актад нийцүүлэн иж бүрэн, үнэн зөв төлөвлөж байх зөвлөмжийг хүргүүлэв.

**Илрүүлэлт 4.** 2024 оны эхний хагас жилийн байдлаар Номын сангийн уншлагын танхимын өрөөг англи хэлний сургалтын танхимын зориулалтаар орон нутгийн өмчийг түрээслүүлсний орлогын 20 хувь 216.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2014 оны 25 дугаар “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, түрээсийн төлбөрийн хэмжээг батлах тухай” тогтоолын 2.14 дэх “... *түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 20 хувийг Орон нутгийн хөрөнгө худалдан борлуулсны орлогын дансанд байршуулна.*” гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт** Түрээсийн орлогыг тухай бүр тогтоосон хувь хэмжээгээр тооцон төсөвт төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 5.** Томилолтоор ажилласан албан хаагч нарт унаа, хоолны хөнгөлөлт 100.0 мянган төгрөг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Засгийн газрын 2019 оны дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” 2.2-д “*Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.3 “хоолны зардал” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.*

**Шийдвэрлэлт** Албан хаагч нарт давхардуулан олгосон унаа, хоолны хөнгөлөлтийг төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

#### **Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:**

##### **4.1 Дүгнэлт:**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 оны эхний

хагас жилийн санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

#### 4.2 Шийдвэрлэлт:

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 10,559.1 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 316.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэх, Төсвийн орлогыг хууль, эрхийн актад нийцүүлэн иж бүрэн, үнэн зөв төлөвлөж байх, Дээд шатны төсвийн захирагчийн баталсан төсвийн хүрээнд унаа, хоолны хөнгөлөлтийг олгож байх, Зам тээврийн сайдын баталсан “Жишиг норм батлах тухай” 2019 оны 390 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах зэрэг 10,283.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

#### Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын захирал, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.


Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус газрын захирал, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж 316.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх, төсөвт буцаан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлсэн болно.

Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2024 оны 11 дүгээр сарын 01-ний дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр мэдэгдэхийг тус газрын захирал, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН АЛБАНЫ  
ДОТООД АУДИТОР

  
Х.БАТБААТАР

ТАНИЛЦСАН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН  
НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ

  
  
С.ШИНЭЧИМЭГ  
НЯГТЛАН БОДОГЧ  
П.УУГАНБИЛЭГ